GOBI



2025 он 06 сар 19 өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

***Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох тухай***

Говь ХК-ийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь хэсгийг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн 2024 оны тусдаа /охин компаниуд ороогүй/ санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх байгууллагаар "Релаэнс Секюритиз Аудит ХХК"-ийг сонгосугай.
2. "Релаэнс Секюритиз Аудит ХХК"-тай байгуулах гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д зөвшөөрсүгэй.
3. Хөндлөнгийн аудитын дүгнэлт, захидлыг хүлээн авч, Эрсдэл аудитын хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.
4. "Релаэнс Секюритиз Аудит ХХК"-тай байгуулах гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/, Бүртгэлийн газрын захирал /Д.Содгэрэл/ нарт тус тус үүрэг болгосугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998...2076357

ТУЗ-ИЙН ДАРГА: .................................... Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: .................................... Б.АМАРСАЙХАН

.................................... Д.ГЭРЭЛМАА

.................................... А.ЖАРГАЛМАА

.................................... Б.ОРГИЛ

.................................... Ц.ОРГИЛБОЛД

.................................... Д.ХУЛАН

.................................... Д.ХҮРЭЛБААТАР

.................................... Б.ЦЭЭНЯМ

"Говь" ХК, Үйлдвэрийн гудамж, 3-р хороо, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот 17062, Монгол улс
Утас: 976-70139977, Факс: 976-70143081, Й-мэйл: info@gobi.mn, Вэб сайт: www.gobi.mn

20 25 он 06 сар 19 өдөр　　　　Дугаар 25　　　　Улаанбаатар хот

***Бүгд Найрамдах Солонгос Улсад охин компани байгуулахыг зөвшөөрөх тухай***

Говь ХК-ийн гадаад зах зээлийг тэлэх, гадаад борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсад охин компани байгуулах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Компанийн дүрмийн 1.6 дугаар заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Бүгд Найрамдах Солонгос Улсад Говь ХК-ийн 100% эзэмшил бүхий охин компанийг "Gobi Cashmere Korea" нэртэй, 100,000,000 (зуун сая) воны дүрмийн сантайгаар байгуулсугай.
2. Тус охин компанийн захирлаар Б.Амарсайханыг томилохыг зөвшөөрсүгэй.
3. Охин компани байгуулахтай холбоотой үйл ажиллагааг Монгол улсын болон Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль, дүрэм, журамд нийцүүлэн зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д даалгасугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 д 2076357

ТУЗ-ИЙН ДАРГА: ............ Ц.БААТАРСАЙХАН

ТУЗ-ИЙН ГИШҮҮД: ............ Б.АМАРСАЙХАН

............ Д.ГЭРЭЛМАА

............ А.ЖАРГАЛМАА

............ Б.ОРГИЛ

............ Ц.ОРГИЛБОЛД

............ Д.ХУЛАН

............ Д.ХҮРЭЛБААТАР

............ Б.ЦЭЭНЯМ